



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дарви сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2024/03/НА-СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Эрдэнэбүрэн хот 2024 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 99047408 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас: 99013699 Цахим хаяг: tsetsegsurena@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Эрдэнэцэцэг Утас: 99019943 Цахим хаяг: erdenetsetsegd@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДАРВИ СУМЫН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН
ЗАХИРАГЧ О.ГАНЦООЖ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Дарви сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дарви сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 3 төсөвт байгууллага, 2 тусгай сан, сумын Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Соёлын төв, зэрэг байгууллагуудын тогтмол зардлыг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд нэгтгэгдсэн байна.

Дарви сумын 2023 оны төсвийн орлогыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн 03 дугаар тогтоолоор татвар, татварын бус орлогыг 369241.9 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 458084.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж орлогыг 88842.6 мянган төгрөгөөр буюу 27.8 хувиар давуулан биелүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ажлын үр дүнд сумын хөрөнгө 516.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Сумын ИТХ-ын 03 тоот тогтоолоор “сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2023 оны хэрэгжилтийг 86.5 хувь буюу “хангалттай” гэж дүгнэжээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)**

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,299,718.8	2,861,025.8
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,495,823.6	2,024,744.0
33	АВЛАГА	733,516.6	743,130.4
35	БАРАА МАТЕРИАЛ	70,378.6	93,151.4
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,575,933.0	3,233,582.2
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,575,933.0	3,233,582.2
39200	Биет хөрөнгө	2,544,058.0	3,201,649.8
39300	Биет бус хөрөнгө	31,875.0	31,932.5
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,875,651.8	6,094,608.0
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	183,900.0	155,170.7
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	183,900.0	155,170.7
41300	Өглөг	183,900.0	155,170.7
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,691,751.8	5,939,437.3
51	Засгийн газрын хувь оролцоо	4,691,751.8	5,939,437.3
51100	Засгийн газрын оруулсан капитал	662,858.9	662,858.9
51200	Хуримтлагдсан үр дүн	3,710,211.2	4,957,896.7
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	318,681.7	318,681.7
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,875,651.8	6,094,608.0

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,673,686.4	4,553,914.9
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,309,952.3	1,775,231.4
110	Орлогын албан татвар	898,374.2	1,407,737.9
1100	Хувь хүний орлогын албан татвар	898,374.2	1,427,003.5
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-19,265.6
113	Хөрөнгийн албан татвар	42,337.5	108,866.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	369,240.6	258,627.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,922,049.7	2,079,937.5
120	Нийтлэг татварын бус орлого	1,922,049.7	2,079,937.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	441,684.3	698,746.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,711,346.9	3,306,229.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,711,346.9	3,306,229.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,461,250.1	3,058,450.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	363,844.6	477,888.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,814.8	60,223.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	333,476.0	90,908.4
2104	Хангамж, бараа материалын зардал	1,313,666.6	1,440,467.2
2105	Норматив зардал	306.1	176.0

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,734.5	6,591.3
2107	Томилолт, зочны зардал	5,242.4	8,539.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,235.0	419,505.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	369,930.2	554,150.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	250,096.8	247,779.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	0.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	962,339.4	1,247,685.5
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	5,970,394.1	0.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-5,008,054.7	1,247,685.5

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан(төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,745,315.6	9,745,315.6
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,691,751.8	4,691,751.8
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,699,806.5	9,699,806.5
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-45,509.1	-45,509.1
9	Тайлант үеийн үр дүн	-5,008,054.7	-5,008,054.7
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,691,751.8	4,691,751.8
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	5,939,437.3	5,939,437.3
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,691,751.8	4,691,751.8
19	Тайлант үеийн үр дүн	1,247,685.5	1,247,685.5

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,701,849.6	3,724,263.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,309,952.3	1,775,231.4
110	Орлогын албан татвар	898,374.2	1,407,737.9
1100	Хувь хүний орлогын албан татвар	898,374.2	1,427,003.5
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-19,265.6
113	Хөрөнгийн албан татвар	42,337.5	108,866.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	369,240.6	258,627.5
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	6,463.1	9,192.0
1181	Газрын төлбөр	359,767.5	245,829.4
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	3,010.0	3,606.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	984,342.7	1,250,285.8
120	Нийтлэг татварын бус орлого	984,342.7	1,250,285.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	407,554.6	698,746.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,375,992.2	1,567,091.9

21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,375,992.2	1,567,091.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	912,632.8	1,318,537.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	365,874.2	491,301.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,823.6	61,831.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	333,452.6	94,411.6
2104	Хангамж, бараа материалын зардал	19,804.5	40,477.5
2105	Норматив зардал	335.3	502.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,056.6	2,735.9
2107	Томилолт, зочны зардал	3,912.4	8,618.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,377.3	391,312.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	112,996.3	227,346.3
211	ХҮҮ	0.0	0.0
212	ТАТААС	0.0	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	463,359.4	248,554.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,325,857.3	2,157,171.3
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,235,265.3	1,628,150.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,235,265.3	1,628,150.8
2200	Дотоод эх үүсвэрээр	1,235,265.3	1,628,150.8
2260	Гадаад эх үүсвэрээр	0.0	0.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-1,235,265.3	-1,628,150.8
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-89,896.0	-100.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	89,896.0	100.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	696.0	528,920.5
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,495,127.5	1,495,823.6
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,495,823.6	2,024,744.0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,136,196.0	2,716,270.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,120,313.5	1,088,470.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,118,401.5	1,086,564.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	480,758.5	476,667.5
210101	Үндсэн цалин	278,490.6	254,090.0
210102	Нэмэгдэл	138,571.2	130,514.0
210104	Урамшуулал	11,279.0	42,049.5
210105	Гэрээт ажлын хөлс	52,417.7	50,014.0

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,094.8	60,094.8
210201	Тэтгэврийн даатгал	40,864.5	40,864.5
210202	Тэтгэмжийн даатгал	4,807.6	4,807.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,846.0	3,846.0
210204	Ажилгүйдлийн даатгал	961.5	961.5
210205	Эрүүл мэндийн даатгал	9,615.2	9,615.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	383,155.0	383,152.6
210301	Гэрэл, цахилгаан	39,983.1	39,981.8
210302	Түлш, халаалт	339,025.5	339,024.4
210303	Цэвэр, бохир ус	4,146.4	4,146.4
2104	Хангамж, бараа материалын зардал	36,784.9	36,776.0
210401	Бичиг хэрэг	2,797.4	2,797.4
210402	Тээвэр, шатахуун	30,387.7	30,383.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,599.8	3,595.0
2105	Нормативт зардал	502.3	502.3
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	502.3	502.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,595.4	12,594.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	280.6	279.3
210604	Урсгал засвар	12,314.8	12,314.7
2107	Томилолт, зочны зардал	8,618.3	8,618.3
210702	Дотоод албан томилолт	8,618.3	8,618.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	115,522.8	87,801.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	113,715.4	86,413.6
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	369.4	99.4
210803	Даатгалын үйлчилгээ	145.0	145.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	225.0	81.8
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	30.0	30.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	915.0	908.7
210807	Газрын төлбөр	123.0	123.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,369.5	20,357.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,835.9	17,823.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,533.6	2,533.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,912.0	1,906.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,912.0	1,906.3
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,912.0	1,912.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,015,882.5	1,627,700.5
2200	Дотоод эх үүсвэрээр	3,015,882.5	1,627,700.5
220001	Барилга байгууламж	1,441,987.5	790,957.3
221001	Их засвар	971,000.0	437,844.2
222001	Тоног төхөөрөмж	235,200.0	146,694.0
223001	Бусад хөрөнгө	367,695.0	252,205.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	100.0
230001	Эргэж төлөгдөх зээл		100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,136,192.0	2,848,190.2
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ		
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,783,087.0	1,640,973.1
132001	Орон нутгийн төсвөөс	1,301,799.5	1,159,685.6

132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	481,287.5	481,287.5
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,353,105.0	1,207,217.1
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	605.0	880.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,120,000.0	1,206,337.1
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	1,232,500.0	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,267,500.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,399,463.1
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2
610001	Төсвийн байгууллага	2	2
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	30	30
620001	Удирдах ажилтан	9	9
620002	Гүйцэтгэх ажилтан	9	9
620003	Үйлчлэх ажилтан	5	5
620004	Гэрээт ажилтан	7	7
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	30	30
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10	10
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8	8
650010	Гэрээт ажилтан	4	4
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	8	8

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	130,694.5	217,458.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	93,243.2	209,852.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	93,243.2	209,852.2
2104	Хангамж, бараа материалын зардал	232.8	2,001.5
210402	Тээвэр, шатахуун	232.8	2,001.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний	30.0	861.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	30.0	861.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	92,980.4	206,989.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	92,980.4	199,928.2
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		7,061.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	37,451.3	7,606.4
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох	37,292.7	7,606.4
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүү	158.6	-
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	130,535.6	217,458.5
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	130,535.6	217,458.5
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилал	69,580.0	204,677.5
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тус	5,448.0	500.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллага	55,507.6	12,281.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	158.9	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 1859235.7 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 389895.9 мянган төгрөгийн алдааг залруулан бүртгэсэн. Үүнд:

- ✓ ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын зардлын үлдэгдэл байгууллагад өгөх өглөгийг 223608.8 мянган төгрөгөөр өглөг илүү бүртгэсэн,
- ✓ Виктор 410 комбайны үлдэгдэл болох 117287.1 мянган төгрөгийн төлбөрийг өглөгөөр тусгаагүй
- ✓ Сангаас 2021-2023 онуудад олгосон малжуулах зээлийн авлагын тооцоо хийж үлдэгдэл 49000.0 мянган төгрөгийг авлагаар тусгаагүй

Аудитаар нийт залруулагдаагүй 1469339.8 мянган төгрөгийн алдаа² илэрснээс 31758.6 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, татварын орлого нэмэгдүүлэх, зээлийн эргэн төлөлтийг шийдвэрлэх 469343.6 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 968237.6 мянган төгрөгийн 3 зөвлөмж өглөө.

3.1 Төлбөрийн акт

3.1.1. Орон нутгийн хөгжлийн сантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Гүйцэтгэлийн санхүүжилт олгохдоо төсөвт тусгагдсан захиалагчийн хяналтын зардал суутгаагүй, магадалшгүй ажлын төсөв, актгүй, зураг төсвийн мөнгө шилжүүлсэн, хүлээлгэн өгсөн баримтгүй байхад төлөвлөсөн зардлыг суутгаж аваагүй 15558.6 мянган төгрөг,

Илрүүлэлт: Хөл бөмбөгийн талбайн ажлын 3.2 сая, наадмын талбайн ажлын зураг төсвийн 6.0 сая, арьс ширний үйлдвэрийн 7.0 сая төгрөгийн зураг төсөв төсвөөс төлсөн байхад төсөвт өртгөөс суутгаж аваагүй 16200.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх, ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 11-р зүйлийн 11.1-д "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, зарцуулалт, тайлагналт, бүртгэл, хяналт болон эцсийн үр дүнг тухайн шатны төсвийн ерөнхийлөн захирагч бүрэн хариуцна", Зам, тээвэр, барилга хот байгуулалтын сайдын 2012 оны 181 тоот тушаалын 1-р хавсралт Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм БНБД 81-94-12 4.11 дэх заалт", Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудыг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдээдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Төлбөрийн акт тогтоох

3.2 Албан шаардлага

3.2.1 Орон нутгийн хөрөнгө оруулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Наадмын талбай, эмнэлгийн барилгын засвар, сургуулийн хөл бөмбөгийн талбайн ажлын гүйцэтгэлийн явцын хяналт хэрэгжүүлээгүй, үндэслэлгүй нэмэлт төсөв баталж санхүүжилт олгосон 120140.6 мянган төгрөг,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Илрүүлэлт: Сангийн бараа материал дансанд мал бүртгэлтэй боловч биетээр байхгүй, тооллого хийж хөрөнгийн үлдэгдлийг баримтжуулаагүй 5000.0 мянган төгрөг,

Илрүүлэлт: Хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ажлын гүйцэтгэл дутуу, гэрээний үүргийн биелэлт хангалтгүй, хугацаандаа ажлаа хүлээлгэн өгөөгүй 298068.5 мянган төгрөг,

Илрүүлэлт: Өвс тэжээлийн тооллого тооцоо хийж авлага, өглөг баталгаажуулаагүй, 2021-2023 оны өвсний үлдэгдлийг баримтжуулж тооцоо нийлээгүй 46134.5 мянган төгрөг нийт 469343.6 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх, ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 11-р зүйлийн 11.1-д "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, зарцуулалт, тайлагналт, бүртгэл, хяналт болон эцсийн үр дүнг тухайн шатны төсвийн ерөнхийлөн захирагч бүрэн хариуцна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалт, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэлт: Албан шаардлага өгөх

3.3 Зөвлөмж

3.3.1 ОНХС, ХХС-тай холбоотой асуудал

Илрүүлэлт: ХХС-ийн насжилт өндөртэй авлага шийдвэрлээгүй, авлагын үр дүн буурсан, зээлийн үлдэгдлийн тооцоо нийлж баталгаажуулаагүй, зээл авсан иргэд зээлийг зориулалтын дагуу зарцуулаагүй, зээлийн эргэлт удааширч байхад эргэн төлүүлэх арга хэмжээ аваагүй, дараагийн зээл авах иргэдийн боломж алдагдсан 52709.4 мянган төгрөг,

Илрүүлэлт: Малын хөлийн татварын орлогоор малын ивомек тариа авч малчдад тараасан нь эргэн төлөгдөх тооцоо хийгдэх эсэх нь тодорхой бус, зөвшөөрөлгүй, эрүүл ахуйн шаардлага хангаагүй 11940.0 мянган төгрөг,

Илрүүлэлт: ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө данс бүртгэлд тусгаагүй 2021 онд 491.6 сая, 2022 онд 76.3 сая, 2023 онд 335.6 сая төгрөгийн хөрөнгийн орлого хөрөнгөд бүртгээгүй 903588.3 мянган төгрөг нийт 968237.6 мянган төгрөгийн зөрчил илэрлээ

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх, ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 11-р зүйлийн 11.1-д "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, зарцуулалт, тайлагналт, бүртгэл, хяналт болон эцсийн үр дүнг тухайн шатны төсвийн ерөнхийлөн захирагч бүрэн хариуцна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй байна

Өгсөн зөвлөмж: ХХС-ийн зээлийг шийдвэрлэх, хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн дараах хяналт хэрэгжүүлж хөрөнгийн тооллого хийх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Дарви ТТЗ	ОНХС-ийн авлага, өглөг зөрүүтэй илэрхийлэгдсэн	3	389.895.9			3	389.895.9	3	389.895.9				
Нийт дүн		3	389.895.9			3	389.895.9	3	389.895.9				

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:								
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
Дарви ТТЗ	Гүйцэтгэлийн санхүүжилт олгоходоо төсөвт тусгагдсан захиалагчийн хяналтын зардал суутгаагүй, магадалшгүй ажлын төсөв, актгүй, зураг төсвийн мөнгө шилжүүлсэн, хүлээлгэн өгсөн баримтгүй байхад төлөвлөсөн зардлыг суутгаж аваагүй	1	15.558.6	1	15.558.6							
	Хөл бөмбөгийн талбайн ажлын 3.2 сая, наадмын талбайн ажлын зураг төсвийн 6.0 сая, арьс ширний үйлдвэрийн 7.0 сая төгрөгийн зураг төсөв төсвөөс төлсөн байхад төсөвт өртгөөс суутгаж аваагүй	1	16.200.0	1	16.200.0							
	Наадмын талбай, эмнэлгийн барилгын засвар, сургуулийн хөл бөмбөгийн талбайн ажлын	1	120.140.6			1	120.140.6					

гүйцэтгэлийн явцын хяналт хэрэгжүүлээгүй, үндэслэлгүй нэмэлт төсөв баталж санхүүжилт олгосон									
Сангийн бараа материал дансанд мал бүртгэлтэй боловч биетээр байхгүй, тооллого хийж хөрөнгийн үлдэгдлийг баримтжуулаагүй	1	5.000.0			1	5.000.0			
Хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ажлын гүйцэтгэл дутуу, гэрээний үүргийн биелэлт хангалтгүй, хугацаандаа ажлаа хүлээлгэн өгөөгүй	1	298.068.5			1	298.068.5			
Өвс тэжээлийн тооллого тооцоо хийж авлага, өглөг баталгаажуулаагүй, 2021-2023 оны өвсний үлдэгдлийг баримтжуулж тооцоо нийлээгүй байна	1	46.134.5			1	46.134.5			
ХХС-ийн насжилт өндөртэй авлага шийдвэрлээгүй, авлагын үр дүн буурсан, иргэдийн зээлийн үлдэгдлийг хүн тус бүртэй тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй	1	52.709.4					1	52.709.4	
Малын хөлийн татварын орлогоор малын ивомек тариа авч малчдад тараасан нь эргэн төлөгдөх тооцоо хийгдэх эсэх нь тодорхой бус, зөвшөөрөлгүй, эрүүл ахуйн шаардлага хангаагүй	1	11.940.0					1	11.940.0	
ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө данс бүртгэлд тусгаагүй 2021 онд 491.6 сая, 2022 онд 76.3 сая, 2023 онд 335.6 сая төгрөгийн хөрөнгийн орлого хөрөнгөд бүртгээгүй	1	903.588.2					1	903.588.2	
Нийт дүн	12	1.859.235.8	1	31.758.6	1	469.343.6	3	968.237.6	

5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Байгууллага, нэгжийн тоо	Санал дүгнэлтийн хэлбэр
---	--------------------------	-------------------------

ХОА-2024/04/НА-СТА-ТШЗ

	Төсвийн захирагчийн ангилал	Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр				Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй					
A	1	2	3	4	5	7	8	9	10	
1	ТШЗ									
2	Төсөл, хөтөлбөр									
3	ЗГТС									
4	ТТЗ	1	1			1				
5	ТЕЗ									
	НИЙТ	1	1			1				